



**МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/526

Улаанбаатар хот

┌ Маягтуудыг цахимаар хөтлөх тухай ┐

Хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-ийн дүрмийн 22 дугаар зүйлийн “а” заалт, Замын даргын 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А-534 дүгээр тушаалыг тус тус үндэслэн галт тэрэгний ачаа тээврийн болон техникийн үзлэгийн анхан шатны бүртгэлийг цахимжуулах зорилгоор ТУШААХ нь:

1. Замын хэмжээнд тээврийн бичиг баримтыг цахимд шилжүүлж байгаатай холбогдуулан “Цахим бичиг баримтын хураангуй буюу галт тэрэгний үзлэгийн хуудас”- ГУ99 маягт болон цахимаар хөтлөх зааврыг 1 дүгээр хавсралт, “Галт тэрэгний үзлэгийн дэвтэр” - ГУ98Б ба ВУ14 маягтыг болон цахимаар хөтлөх зааврыг 2 дугаар хавсралт, “Ачилтын вагонд ачаа тээврийн болон техникийн үзлэг хийж бүртгэх дэвтэр”- ГУ98А маягт болон цахимаар хөтлөх зааврыг 3 дугаар хавсралт, “Галт тэрэгнээс техникийн гэмтэлтэй вагон салгах мэдэгдэл” ВУ-23, ВУ-23Б цахим маягт, “Техникийн гэмтэлтэй вагоныг өөр өртөөнд байрлах засварын газарт явуулах дагалдах хуудас” ВУ-26, ВУ-26Б цахим маягт, “Вагоны гэмтлийг засварлаж, тээвэрт хүлээлгэн өгөх хуудас” ВУ-36 цахим маягт болон хөтлөх зааврыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Тушаал гарсан өдрөөс эхлэн “Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем” программ хангамжийн технологийн хэсгийг нэвтрүүлж буй Тээвэр зохион байгуулалтын алба, Вагоны аж ахуйн албаны харьяа бүтцийн нэгжүүдэд мөрдүүлсүгэй.

3. Галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой дээрх дэвтэр, маягтыг цахимаар бүртгэн мэдээлэл дамжуулахтай холбогдуулан сервер, сүлжээ, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Тээвэр зохион байгуулалтын албаны дарга (М.Цогт), Вагоны аж ахуйн албаны дарга (Л.Болд), Дохиолол холбооны албаны дарга (Л.Гунгаажанцан), Мэдээллийн технологийн албаны дарга (Х.Анар) нарт үүрэг болгосугай.

4. Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, ачааны бүрэн бүтэн байдалтай холбоотой цахим маягтуудыг хөтлөх программ хангамжийн үнэн зөв, тасралтгүй байдлыг хангаж, засвар шинэчлэлтийг батлагдсан техникийн даалгаврын дагуу цаг тухайд нь хийж ажиллахыг Мэдээллийн технологийн албаны дарга (Х.Анар)-д даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан УБТЗ-ын даргын 2017 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А-292 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


1601233015

6. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тээвэрлэлт, хөдөлгөөн хариуцсан замын орлогч дарга (Д.Амарбаясгалан), Хөдлөх бүрэлдэхүүний засвар, ашиглалт хариуцсан замын орлогч дарга (Б.Гантөмөр) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ХЭРЛЭН



Цахим бичиг баримтын хураангуй буюу галт тэрэгний үзлэгийн хуудас – ГУ-99 маягт

Натурка №:

Илгээсэн (хүлээн авсан) замын нэр:

Хүлээн авсан замын №.....

[illegible]

/ /

/

Цахим бичиг баримтын хураангуй буюу галт тэрэгний үзлэгийн хуудас –
ГУ99 маягт хөтлөх заавар

ГУ99 маягт нь өртөө (МЧ) – ийн дараах ажлын байруудын ажлын дараалал, гүйцэтгэлээс шууд хамааралтайгаар АТМС-ТКАС (цаашид ТКАС гэх), АТМС-Натурка (цаашид Натурка гэх) программын холболтын хүрээнд автоматаар бүртгэгдэнэ. Ээлжийн ажлын хугацаанд программд нэвтэрсэн ажилтны нэвтрэх нэр, нууц үг нь тухайн ажлын байранд ажил үүрэг гүйцэтгэсэн гарын үсгийг төлөөлнө.

АТМС-Натурка программын хувьд вагоны байршлын шаардлага

Тооцооны оператор Ткас программд тээврийн бичиг баримт үйлдэх үед уг вагон нь техникийн конторчийн Натурка программд байршлын хувьд дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

1. Галт тэрэгний бүрэлдэхүүнд тухайн өртөөнд ирсэн байх.
2. Өртөөний паркийн болон салбар замд байх.

Өртөө, МЧ-ийн ажлын байруудын гүйцэтгэх ажлын дараалал

1. Ачаа вагон хүлээлцэгч

1.1. Өртөөний парк дээр ажиллаж буй АВХ зэргэлдээ өртөөнөөс Натурка программаар илгээсэн галт тэрэгний ГУ99 маягт цахимаар урьдчилан ирсэн байх ба галт тэргийг хүлээн авахаас өмнө үзлэгийн хуудсыг хэвлэж, галт тэргэнд ачаа тээврийн үзлэг хийхдээ бодит байдалд тулган шалгаж тэмдэглэнэ. Үзлэгийн үр дүнг ирсэн галт тэрэгний натурка болон бичиг баримтын уут дахь илгээсэн өртөөний хуанлийн тэмдэг бүхий ГУ99 маягт ба тээврийн бичиг баримттай тулган ээлжийн ахлах - (технологийн горимд заагдсан) – д илтгэн дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох дүрэм, зааврын дагуу арга хэмжээ авна.

1.2. Салбар замд ажиллаж буй АВХ нь буулгалтын Натурка программд ирсэн галт тэргийг техникийн конторч Натурка программаар хүлээн авсны дараа галт тэрэг хүлээн авсан өртөөний хувьд орон нутгийн вагонуудыг автоматаар ялгаж бүртгэсэн байх бөгөөд цахимаар ачилт, буулгалтын дэвтэрт бичихийн өмнө тээврийн бичиг баримтыг нягтлан ачааны ажиллагаа хийх салбар замыг сонгон бичнэ. Ээлжийн ажлын хугацаанд өөрийн хяналтын дор салбар замд ачааны ажиллагаанд тавьсан вагоны санамжийг нээж, ачааны ажиллагаа дууссан вагоны санамжийг хаана. Энэ үед уг вагон программын хувьд галт тэрэгний бүрэлдэхүүнд байх ёсгүй.

2. Тооцооны оператор нь өртөөний хувьд орон нутгийн вагоны ачиж, бууж (хаяг сольж) дуусаад АВХ-ийн хаасан санамж (цахим болон цаас) - ийг тасалж, тооцоо хийн тээврийн бичиг баримт үйлдэнэ. Мөн орон нутгийн вагоны бичиг баримтыг үйлдэхдээ цахим ба цаасан бичиг баримттай эсэхийг Ткас программд ялгаж үйлдэнэ. Тайлбар: Орон нутгийн вагоны санамжийг АВХ программд хаагаагүй буцах, шинэ бичиг баримтаар хаяг солих, ачилтын гэх мэт дараагийн ажиллагааны бичиг баримтыг үйлдсэн тохиолдолд техникийн конторчийн Натурка программд тухайн вагонд давхар цахим бичиг баримтууд татагдаж, жин тонн татагдсан бичиг баримтын тоогоор нэмэгдэж харагдах бөгөөд АВХ буулгалтын санамж хаахад татагдсан бүх бичиг баримтыг замын байдалд

вагоны цахим бичиг баримт хоосноор харагдах тул ачааны ажиллагааны дарааллаар технологит ажлыг гүйцэтгэх шаардлагатай.

3. Техникийн конторчин (технологийн горимд заасан ажилтан) нь өртөөний хувьд орон нутгийн вагоны цахим тээврийн бичиг баримтыг нягтлан Натурка программд татагдсан мэдээллийг үнэн, зөв эсэхийг тулгах, засах эрхтэй бөгөөд хүлээн авсан Галт тэрэгний биечилсэн хуудас (ДУ1 маягт гэх), ГУ99 маягт, цаасан бичиг баримтын дутагдалд ЕМА тавих, илгээх цахим бичиг баримтыг үндэслэн галт тэрэгний биечилсэн хуудас үйлдэх, галт тэрэгний биечилсэн хуудас - ДУ1, галт тэрэгний найрлагын дагуу цахим бичиг баримт - ГУ99 маягтын бүрэн, зөв байдлыг хариуцна. (Хилийн өртөөний техникийн конторчин Натурка программд бүх вагоны цахим тээврийн бичиг баримтыг устгах, татах бүрэн эрхтэй.)



“УБТЗ” ХНН-ийн даргын 2023 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 1526 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

Галт тэрэгний үзлэгийн цахим дэвтэр – ГУ98Б, ВУ14 маягт

Г/т сонголт
Хүлээн авсан
Илгээсэн

(ИРСЭН)
(ЯВСАН)

Хугацааны сонголт
Эхлэх огноо
Төгсөх огноо

[illegible]

Галт тэрэгний үзлэгийн цахим дэвтэр – ГУ98Б, ВУ14
маягт хөтлөх заавар

АТМС-Натурка программын хувьд галт тэрэгний байршлын шаардлага

Ээлжийн ажлын хугацаанд программд нэвтэрсэн ажилтны нэвтрэх нэр, нууц үг нь тухайн ажлын байранд ажил үүрэг гүйцэтгэсэн гарын үсгийг төлөөлнө.

Галт тэрэгний үзлэгийн цахим дэвтрийг хөтлөхөд АТМС-Натурка программд галт тэрэгний бүрэлдэхүүнд дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Ирсэн галт тэрэгний хувьд хүлээн авсан өртөө АТМС-Натурка программаар хүлээн авсан байх.
2. Явах галт тэрэгний хувьд илгээх өртөө АТМС-Натурка программд найруулж бэлэн болгосон байх.
3. Технологит ажлын шаардлагаас хамаарч ПТО-ийн давтан үзлэгт өгсөн галт тэрэг ачаа тээврийн хэсэгт хоосон харагдаж болно.

Өртөөний болон ТҮГ-ын ажлын байруудын гүйцэтгэх ажлын дараалал

1. Ирсэн галт тэрэг:

1.1. Техникийн конторчин: Галт тэргийг өртөөнд орж ирсэн бодит цаг болон хүлээн авсан замаар программд хүлээн авах бөгөөд тухайн галт тэрэгний өртөөнд хийгдэх ажиллагааны ангиллыг зөв тодорхойлсон байна.

1.2. Өртөөний жижүүр: Ирсэн галт тэргийг хамгаалалтад авч техникийн болон ачаа тээврийн үзлэг эхлэх цагийг программд оруулна. Галт тэрэгний бүрэлдэхүүнийг бодит байдалд хэсэгчилсэн үзлэгт өөр өөр замаар өгсөн бол программд мөн адил бүртгэнэ.

1.3. Ахлах вагон үзэгч: Өртөөний жижүүр ирсэн галт тэргийг үзлэг хийх зөвшөөрөл өгсөн даруйд өртөөний парк дээрх галт тэргүүдэд өртөөний жижүүрийн тогтоосон техникийн үзлэг хийх дарааллын дагуу үзлэг эхлэх цаг минутыг бүртгэнэ. Галт тэргэнд техникийн үзлэг хийж дуусаад үзлэгийн үр дүн, үзлэг дууссан цагийг программд бүртгэнэ. Үзлэг дууссаны дараа галт тэргэнд байгаа техникийн гэмтэлтэй вагоныг галт тэрэгнээс салгах тухай мэдэгдэх цахим хуудас ВУ-23, ВУ-23Б маягт, засварт вагон илгээх тухай дагалдах цахим хуудас ВУ-26, ВУ-26Б маягтуудыг үйлдэнэ.

1.4. Ачаа вагон хүлээлцэгч: Өртөөний жижүүр ирсэн галт тэргийг үзлэг хийх зөвшөөрөл өгсөн даруйд өртөөний парк дээрх галт тэргүүдэд ачаа тээврийн үзлэг хийх дарааллын дагуу сонголт хийн үзлэг эхлэх цаг минутыг бүртгэнэ. Галт тэргэнд ачаа тээврийн үзлэг хийж дуусаад үзлэгийн үр дүн, үзлэг дууссан цагийг программд бүртгэнэ. Шаардлагатай тохиолдолд цахимаар ЕМА үйлдэнэ.

2. Явах галт тэрэг:

- Явах галт тэрэгний бүрэлдэхүүнд ВУ-23, ВУ-23Б маягттай вагон орохгүй.
- ВУ-26, ВУ-26Б маягттай вагон чиглэлийн бус явах галт тэргэнд холбогдохгүй.

2.1. Техникийн конторчин: Явах галт тэргийг илгээх зам, найрлагын дагуу программд бэлэн болгосон байна.

2.2. Өртөөний жижүүр: Явах галт тэрэг, бүрэлдэхүүнийг хамгаалалтад авч техникийн болон ачаа тээврийн үзлэг эхлэх цагийг программд оруулна. Галт тэрэгний бүрэлдэхүүнийг бодит байдалд хэсэгчилсэн үзлэгт өөр өөр замаар өгсөн бол программд мөн адил бүртгэнэ.

2.3. Ахлах вагон үзэгч: Өртөөний жижүүр явах галт тэргийг үзлэг хийх зөвшөөрөл өгсөн даруйд өртөөний парк дээрх галт тэргүүдэд өртөөний жижүүрийн тогтоосон техникийн үзлэг хийх дарааллын дагуу үзлэг эхлэх цаг минутыг бүртгэнэ. Галт тэргэнд техникийн үзлэг хийж дуусаад үзлэгийн үр дүн, үзлэг дууссан цагийг программд бүртгэнэ.

2.4. Ачаа вагон хүлээлцэгч: Өртөөний жижүүр явах галт тэргийг үзлэг хийх зөвшөөрөл өгсөн даруйд өртөөний парк дээрх галт тэргүүдэд ачаа тээврийн үзлэг хийх дарааллын дагуу сонголт хийн үзлэг эхлэх цаг минутыг бүртгэнэ. Галт тэргэнд ачаа тээврийн үзлэг хийж дуусаад үзлэгийн үр дүн, үзлэг дууссан цагийг программд бүртгэнэ. Шаардлагатай тохиолдолд цахимаар ЕМА үйлдэнэ.



Г/т-ээс бичих	Өртөөний паркаас бичих	ГУ98А дэвтэр
---------------	------------------------	--------------

Дуусах огноо:

[illegible]

Ачилтын вагоныг ачаа тээврийн үзлэгт бэлтгэх цахим дэвтэр –
ГУ98А маягт хөтлөх заавар

АТМС-Натурка программын хувьд ачилт хийх вагонуудад тавигдах шаардлага

1. Ачааны диспетчер (ДСЦг) эсвэл ачаа вагон хүлээлцэгч (АВХ) нь АТМС-Натурка программд байршлын хувьд дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
 - 1.1. Галт тэрэгний бүрэлдэхүүнд тухайн өртөөнд ирсэн байх.
 - 1.2. Өртөөний паркийн болон салбар замд байх.
2. Ачилтад өгч байгаа вагонууд нь техникийн байдлын хувьд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2.1. Галт тэрэгнээс салгах тухай мэдэгдэх цахим хуудас ВУ-23, ВУ-23Б маягт өгөгдөөгүй байх.
 - 2.2. Вагон илгээх тухай мэдэгдэх дагалдах цахим хуудас ВУ-26, ВУ-26Б маягт өгөгдөөгүй байх.

Өртөөний болон ТҮГ-ын ажлын байруудын гүйцэтгэх ажлын дараалал

Зарим өртөөний ажлын онцлогоос шалтгаалан ДСЦг, АВХ ачилтын вагоныг сонгох боломжтой байна.

1. Өртөөний жижүүр

- 1.1. Ачилтын захиалгын дагуу ачилт хийх вагонуудыг галт тэрэгнээс болон өртөөний паркаас цахим дэвтэрт сонгож бүртгэнэ.
- 1.2. Сонгосон бүрэлдэхүүн болон вагоныг хамгаалалтад авч техникийн болон ачаа тээврийн үзлэг эхлэх цаг, замыг программд оруулна.

2. Ахлах вагон үзэгч:

- 2.1. Өртөөний жижүүр ачилтын вагоныг техникийн үзлэг хийх зөвшөөрөл өгсөн даруйд технологийн дагуу үзлэг эхлэх цаг минутыг бүртгэнэ.
- 2.2. Ачилтын вагонд техникийн үзлэг хийж дуусаад үзлэгийн шийдвэр, үзлэг дууссан цагийг программд бүртгэнэ.

3. Ачаа вагон хүлээлцэгч:

- 3.1. Өртөөний жижүүр ачилтын вагоныг ачаа тээврийн үзлэг хийх зөвшөөрөл өгсөн даруйд технологийн дагуу үзлэг эхлэх цаг минутыг бүртгэнэ.
- 3.2. Ачилтын вагонд ачаа тээврийн үзлэг хийж дуусаад үзлэгийн тэмдэглэл, үзлэг дууссан цагийг программд бүртгэнэ.

Тайлбар:

Тээвэр зохион байгуулалтын алба болон вагоны аж ахуйн албаны АТМС-Натурка программд нэвтрэх эрх бүхий ажилтан ачилтын вагоныг ачаа тээврийн үзлэгт тэнцсэн эсэхийг өөрийн программаас хайн шалгах бөгөөд дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

1. Тухайн вагон ГУ98А цахим дэвтэрт 2 дахин бичигдсэн бол хамгийн сүүлийн огноо, хугацаа бүхий шийдвэрийг сонгоно.
2. Ачааны нэрийг зөвшилцсөний үндсэн дээр ДСП үзлэг эхлүүлсэн цагаас 2 цагийн дотор зөвхөн АВХ солих эрхтэй.
3. Цахим ГУ98А дэвтрээс багана дахь өгөгдөл бүрээр эрэмбэлэх, шүүх боломжтой.

“УБТЗ” ХНН-ийн даргын 2023 оны 06 дугаар сарын 07 -ны өдрийн 1526 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

**Ачааны вагоныг засварт өгсөн тухай мэдэгдэх цахим хуудас
ВУ-23, ВУ-23Б маягт,
Вагон илгээх тухай дагалдах цахим хуудас ВУ-26, ВУ-26Б маягт,
Вагон засвараас хүлээн авсан тухай мэдэгдэх цахим хуудас
ВУ-36 маягт**

Маягт ВУ-23 шинээр үүсгэх

Вагон № : 805978 Ирсэн цаг, минут : 2023-05-11 9:45:00 AM Г/т № : 3103

Ачааны мэдээлэл

☒ Ачаатай ☐ Хоосон

Ачааг буулгах шаардлагатай эсэх : ☐

Сүүлчийн засварт орсон огноо, төрөл : 2022-09-12 Депо засвар Үйлдвэрлэсэн огноо : 1976-06-06

Гэмтлийн нэр :

Техникийн нэгдсэн байцаалтаар болон үзлэгээр илэрсэн гэмтэл :

Засварт өгөх өртөөний нэр :

Засварт өгөх замын нэр :

Жижүүрт хүлээлгэн өгсөн : 00:00

Жижүүрийн нэр :

Вагон үзэгчийн нэр : 84950 Admin

Салгах хуудсыг бичсэн : 2023-05-12 12:57

ВУ-23 үүсгэх Болlox

Форма ВУ-23Б шинээр үүсгэх

Вагон № : 65569477 Ирсэн цаг, минут : 2023-05-11 9:45:00 AM Г/т № : 3103

Эзэмшигч байгуулга :

Ачааны мэдээлэл

☒ Ачаатай ☐ Хоосон

Ачааг буулгах шаардлагатай эсэх : ☐

Сүүлчийн засварт орсон огноо, төрөл : 2022-10-09 Депо засвар Үйлдвэрлэсэн огноо : 1991-10-01

Гэмтлийн нэр :

Техникийн нэгдсэн байцаалтаар болон үзлэгээр илэрсэн гэмтэл :

Засварт өгөх өртөөний нэр :

Засварт өгөх замын нэр :

Жижүүрт хүлээлгэн өгсөн : 00:00

Жижүүрийн нэр :

Вагон үзэгчийн нэр : 84950 Admin

Салгах хуудсыг бичсэн : 2023-05-12 13:00

ВУ-23 үүсгэх Болlox

Форма ВУ-36 Вагоныг засаж дууссан тухай акт

Мэдэгдэл № :

Вагон №	Ваг. төр.	Гол тоо	Замын код	Байрлал буй замын нэр
1				

Засварын депозийн даргын код, нэр :

ВУ-36 бичсэн : 23-May-23 11:52

Вагоныг засаж дууссан ба засварын замаас гаргасан тухай өртөөний жижүүрт мэдэгдсэн хугацаа : 23-May-23 11:51

Өртөөний жижүүрийн код, нэр : 27956 Төгсжаргал

Жижүүр хүлээн авсан огноо, цаг, минут : 23-May-23 13:48

ВУ-36 хүлээн авах Болlox

Форма ВУ-26 шинээр үүсгэх

Дамжуулахаар :

Вагон № : 65569477 төрөл : пв Гол : 4 Өртөөнд ирсэн огноо, цаг : 2023-05-11 9:45:00 AM

Явуулах өртөө : 84 Улаанбаатар

Засварын пункттай очих станц :

Вагон нь поездтой буку сүүлд явах эсэх : ☒ Аль ч хэсэгт ☐ Дунд ☐ Зөвхөн сүүлд

Сүүлчийн засварт орсон огноо : 2022-10-09 сүүлчийн засварын төрөл : Депо засвар

Вагон хүргэгдэх (засварын газар) :

Ямар төрлийн засвар хийх вэ?

Дагалдах хуудсыг бичсэн : 2023-05-12 13:02

Ахлах үзэгчийн код, нэр : 84950 Admin

Жижүүр хүлээн авсан огноо, цаг : 00:00 Жижүүрийн нэр :

Засварын замд ирсэн огноо, цаг, мин : 00:00 Мастерын нэр :

ВУ-26 үүсгэх Болlox

Маягт ВУ-26Б шинээр үүсгэх

Дамжуулахаар :

Вагон № : 65569477 төрөл : пв Гол : 4 Өртөөнд ирсэн огноо, цаг : 2023-05-11 9:45:00 AM

Явуулах өртөө : 84 Улаанбаатар

Засварын пункттай очих станц :

Вагон нь поездтой буку сүүлд явах эсэх : ☒ Аль ч хэсэгт ☐ Дунд ☐ Зөвхөн сүүлд

Сүүлчийн засварт орсон огноо : 2022-10-09 сүүлчийн засварын төрөл : Депо засвар

Вагон хүргэгдэх (засварын газар) :

Ямар төрлийн засвар хийх вэ?

Дагалдах хуудсыг бичсэн : 2023-05-12 13:02

Ахлах үзэгчийн код, нэр : 84950 Admin

Жижүүр хүлээн авсан огноо, цаг : 00:00 Жижүүрийн нэр :

Засварын замд ирсэн огноо, цаг, мин : 00:00 Мастерын нэр :

ВУ-26 үүсгэх Болlox

**Ачааны вагоныг засварт өгсөн тухай мэдэгдэх цахим хуудас
ВУ-23, ВУ-23Б маягт,
Вагон илгээх тухай дагалдах цахим хуудас ВУ-26, ВУ-26Б маягт,
Вагон засвараас хүлээн авсан тухай мэдэгдэх цахим хуудас
ВУ-36 маягт хөтлөх заавар**

АТМС-Натурка программын хувьд цахим маягтуудыг үүсгэхэд тавигдах шаардлага

Цахим маягтуудыг үүсгэхэд АТМС-Натурка программд вагонууд нь дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Цахим маягт үүсгэх вагон нь тухайн өртөөний хүлээн авсан галт тэрэгний найрлага эсвэл өртөөний паркад байх.
2. Явах галт тэргэний хувьд ПТО-н үзлэг дууссан цагийг оруулахаас өмнө цахим маягтуудыг үүсгэсэн байх.

Өртөөний болон ТҮГ-ын ажлын байруудын гүйцэтгэх ажлын дараалал

1. Ахлах вагон үзэгч:

1.1. Өртөө болон салбар замд байгаа эсвэл ирсэн галт тэргэн дэх вагоныг салгаж, салгалттай засвараар засварлах тохиолдолд засварт өгөх тухай мэдэгдэх цахим хуудас ВУ-23, ВУ-23Б маягтыг үүсгэж, засварын ажлыг гүйцэтгэхээр өртөөний салгалттай засварын замыг сонгон программд оруулна.

1.2. Салгалттай засварын газарт вагон илгээх тухай мэдэгдэх дагалдах цахим хуудас ВУ-26, ВУ-26Б маягтаар явуулах вагонд хүрэх өртөө, ямар төрлийн засвар хийх талаар тэмдэглэлийг хийж цахим маягтыг үүсгэнэ.

1.3. Вагон илгээх тухай мэдэгдэх дагалдах цахим хуудас ВУ-26, ВУ-26Б маягтаар хүрэх өртөөнд ирсний дараа засварт өгөх тухай мэдэгдэх цахим хуудас ВУ-23, ВУ-23Б маягтыг үүсгэнэ.

2. Техник үйлчилгээний газрын дарга, мастер, вагон депогийн гэмтлийн техникч: Вагон депо болон салгалттай засвараар засварлаж дууссан вагоныг Вагон засвараас хүлээн авсан тухай мэдэгдэх хуудас ВУ-36 маягтыг цахимаар үүсгэнэ.

3. Өртөөний жижүүр:

Ахлах үзэгчийн вагонд үүсгэсэн цахим маягтуудыг цаг тухайд нь цахимаар хүлээн авч баталгаажуулна.

4. Техникийн конторчин: Засварт өгөх тухай мэдэгдэх цахим хуудас ВУ-23, ВУ-23Б маягттай вагоныг хоосон бол шууд, ачаатай бол ачаанаас суларсны дараа цахимаар өгөгдсөн засварын ажлыг гүйцэтгэх салгалттай засварын замд АТМС-Натурка программаар цаг тухайд нь байрлуулна.